



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/97

Хэрлэн сум

Хурдан морины уралдаан зохион
байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хурдан морины уралдаан, сунгаан, үсэргээ, бооцоот уралдаан зохион байгуулахыг 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хориглосугай.

2. Дурдсан хугацаанд хурдан морины уралдаан, сунгаан, үсэргээ, бооцоот уралдаан зохион байгуулахгүй байхыг иргэд, нийт уяачдад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Цагдаагийн газар (Д.Батхүү), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Б.Энх-Эрдэнэ), “Сэцэн ханы хүлэг” уяачдын холбоо (н.Тэгшбаяр) үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), Цагдаагийн газар (Д.Батхүү), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Б.Энх-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010311